



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит бус 06 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 06 дугаар хуралдааныг 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 06 дүгээр хуралдаанаар Домэйн нэрийн зохицуулалт, цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ-ийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) тухай зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 6 тогтоолыг баталж, хуралдааны 1 тэмдэглэлээр холбогдох бүтцийн нэгжид удирдамж, чиглэл өгч шийдвэрлэсэн.

Тус хорооны 2023 оны ээлжит бус 06 хуралдаанаар хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын хүрээнд хүрээнд ЦЕГ, Прокуророос ирүүлсэн албан тоотын дагуу zarig.mn цахим хуудасны хандалтыг түр хугацаагаар хязгаарласантай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон эрх ашиг нь хөндөгдөж байгаа талуудын төлөөлөл оролцсон хамтарсан уулзалтын тохиролцооны дагуу “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журмын хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээний саналын тухай” танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг авч хэлэлцээд, Хорооны хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар “Домэйн нэрийн зохицуулалтын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Тэмдэглэлийг батлав. Энэхүү тэмдэглэлд, ЦХХХЯ-ны сайдаас өгсөн удирдамж чиглэл, хамтарсан уулзалтын үр дүнг хэрэгжүүлэх, тус хорооны хуралдааны үеэр дарга, гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг үндэслэн дараах удирдамж, чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/, Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар /Т.Батболд/-т үүрэг болгохоор тус тус тогтов. Үүнд: Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Домэйн нэрийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа ЦХХХЯам, оролцогч талуудын хамтарсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах; Домэйн нэрийн зохицуулалтын эрх зүйн шинэ зохицуулалтын орчин бий болгох арга хэмжээ эхэлсэн, хэлэлцэх, хууль батлагдсантай холбогдуулан ХХЗХ-ны дэргэд тусгайлсан ажлын хэсэг байгуулж, Захиргааны Ерөнхий хуулийн дагуу холбогдох зохицуулалт, баримт бичгийг хуульд нийцүүлэн тогтоолоор батлуулах, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд хянуулан бүртгүүлэх зэрэг болно.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 06 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ-ийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний

дүгнэлт бүхий 2 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 2 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 153 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Асралт хөхий ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 154 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож тус тус шийдвэрлэв.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-12-13